

тусгай орхын

## Гачууртын усан сан 43.5 мянган хүнийг ундны усаар хангадаг

Улаанбаатар хотын усан хангамжийг нэмэгдүүлэх "Гачууртэх үүсвэр" төслийг Япон улсын буцалтгий тусламжаар 2011-2014 онд хэрэгжүүлсэн. Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөлд ойролцоогоор 59 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүний үр дүнд Гачууртад хоногт 25.2 мянган м3 усыг олборлон түгээх чадалтай эх үүсвэрийг шинээр байгуулжээ. Бид Гачууртын ундны усны эх үүсвэрийн усан сантай танилцаа.

Тус усан сан нь одоогийн байдлаар хоногт дунджаар хотын нийт ундны усны хэрэглээний 5-8 хувийг хангадаг гэнэ. Энэ нь 43.5 мянган хүнийг ундны усаар хангадаг гэсэн үг. "Гачуурт эх үүсвэр" төслийн хүрээнд 21 гүний худаг, хлоржуулалтын систем бүхий удирдлагын төв зэрэг инженерийн гол байгууламжуудыг шинээр барьжээ. Мөн Ганчууртын усан сан болон Зүүнхойд бүсийн усан

сангхолбосон 18.8 км магистрал шугам, 7.1 км дамжуулах болон цуглуулах шугамуудыг тавьсан байна. Магистрал шугамыг барихдаа Японд үйлдвэрлэсэн шилээр хүчинтэсэн нийлмэл хоолойг ашиглажээ. Энэ нь ундны усны аюулгүй байдал, шугаманд зэв үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой гэж мэргэжилтнүүд тайлбарлав. Харин 30-40 метрийн гүнээс ус олборлодог учир нянгийн бохирдлыг устгах үүднээс хлоржуулалт хийдэг байна. Ус сувгийн удирдах газрын Инженерийн бодлогын хэлтсийн дарга Н.Одхүү "Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тоо жил бүр нэмэгдсэнээр гэр хороолол тэлэх болсон. Үүнээс үүдэн гэр хороолол болон Улаанбаатар хотын баруун хэсгийг ус хангамжийг сайжруулах шаардлага бий болсон. Ганчууртын эх үүсвэрийн станц одоогоор өөрийн бүрэн хүчин

чадлынхаа 30 орчим хувийг ашиглаж байна. Улаанбаатар хотыг баруун тийш хөгжүүлэх мастер төлөвлөгөөний транзит шугамууд татаж эхэлж байгаа. Өөрөөр хэлбэл, Сансар, КТМС-ийн хойно байрлах усан сангаас III, IV хорооллын усан сан, цаашлаад Талх чихэр ХК-ийн ойролцоо усан сантай холбож, Баянхошуу, Толгойт, Баруунтурууныг усан сангаар холбох төлөвлөгөө явж байгаа. Энэ усан сангүүд ашиглалтад орчихвол Ганчуурын ус хангамжийн үүсвэр бүрэн хүчин чадлаараа ажиллана. Энэ төслийн хүрээнд Дарь Эх, Дамбадаржкаа, Хайлаат, Чингэлтэй, Дэнжиийн мянга, Толгойт, Баянхошуу гэсэн гэр хорооллын хэсгүүд төвлөрсөн шугам сүлжээнд холбогдчихсон. Үүнээс гадна шугам сүлжээтэй ойр орчим байгаа айлууд төв шугамд холбогдоод амжсан" хэмээн ярилаа.

Э.ЯНЖМАА